



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2026 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)  
Аудитын менежер: Т.Батсайхан  
Утас: 70592225  
Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Ж.Угтахбаяр  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Ugtakhbayarj@audit.gov.mn](mailto:Ugtakhbayarj@audit.gov.mn)  
Аудитор: Б.Сарангуа  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Saranguab@audit.gov.mn](mailto:Saranguab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>6</b>
<b>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</b>	
<b>/төгрөгөөр/.....</b>	<b>6</b>
<b>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</b>	
<b>/төгрөгөөр/.....</b>	<b>7</b>
<b>2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</b>	
<b>/төгрөгөөр/.....</b>	<b>8</b>
<b>2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>	
<b>/төгрөгөөр/.....</b>	<b>10</b>
<b>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....</b>	<b>10</b>
<b>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....</b>	<b>11</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>12</b>
<b>3.1 Төлбөрийн акт .....</b>	<b>12</b>
<b>3.2 Албан шаардлага.....</b>	<b>13</b>
<b>3.3 Зөвлөмж.....</b>	<b>13</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>16</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

  
**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208. Цахим хаяг: dundgovia@audit.gov.mn

\_\_\_\_\_ № \_\_\_\_\_ //  
тнэй \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ  
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад төсвөөс олгох санхүүжилтийг 230.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь өмнөх оноос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, зардлууд өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Харин тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь элэгдлээ бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж, орлого авсан байна.

### Бусад асуудлын хэсэг

4826050041



Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилт, 33 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 93 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүдэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	381,932,156.49	367,563,171.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,046,285.79	2,534,285.79
311	Кассд байгаа бэлэн мөнгө		
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,046,285.79	2,534,285.79
3121	Төгрөг	4,046,285.79	2,534,285.79
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	4,046,285.79	2,534,285.79
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	10,554,935.00	10,098,807.87
335	Бусад авлага	10,554,935.00	10,098,807.87
3351	Байгууллагаас авах авлага	10,554,935.00	10,098,807.87
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	367,330,935.70	354,930,077.83
354	Хангамжийн материал	365,490,935.70	354,930,077.83
3541	Бичиг хэргийн материал	1,998,400.00	1,809,900.00
3542	Аж ахуйн материал	95,174,227.83	94,129,177.83
3545	Барилгын засварын материал	3,195,500.00	
3547	Бусад хангамжийн материал	265,122,807.87	258,991,000.00
356	Мал амьтад	1,840,000.00	
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,763,195,381.14	2,319,172,764.59
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,763,195,381.14	2,319,172,764.59
392	Биет хөрөнгө	1,744,128,966.55	2,300,293,674.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,759,021,959.09	2,138,623,549.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(523,121,458.85)	(641,838,483.74)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	368,029,000.00	612,763,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(180,340,055.74)	(190,505,916.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,737,756.16	314,464,367.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,394,486.15)	(90,655,702.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,329,919.66	167,124,423.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,709,206.51)	(55,460,729.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	67,659,950.00	65,350,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,084,411.11)	(19,570,833.33)
393	Биет бус хөрөнгө	19,066,414.59	18,879,089.63
39301	Программ хангамж	6,096,625.00	6,096,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,126,210.41)	(2,313,535.37)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,096,000.00	15,096,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,145,127,537.63	2,686,735,936.08
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,025,595.60	18,286,149.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,025,595.60	18,286,149.00
413	Өглөг	1,025,595.60	18,286,149.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,025,595.60	16,421,349.00
4136	Бусад өглөг		1,864,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг		1,864,800.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,144,101,942.03	2,668,449,787.08
51	Засгийн газрын хувь оролцоо	2,144,101,942.03	2,668,449,787.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,377,134.26	263,377,134.26
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	263,377,134.26	263,377,134.26
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	1,591,632,330.87	2,115,980,175.92
5121	Өмнөх үеийн үр дүн	1,591,632,330.87	1,591,632,330.87
5122	Тайлант үеийн үр дүн		524,347,845.05

513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	289,092,476.90	289,092,476.90
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,145,127,537.63	2,686,735,936.08

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,352,458,921.38	1,896,628,337.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	533,822,288.51	866,497,477.31
120	Нийтлэг татварын бус орлого	533,822,288.51	866,497,477.31
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,425,535.00	5,228,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,870,600.00	5,228,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,554,935.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	455,718,404.28	858,153,877.31
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	62,678,349.23	3,115,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	818,636,632.87	1,030,130,860.29
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,332,232.87	35,957,360.29
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,699,087.00	8,310,684.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,633,145.87	27,646,676.29
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	763,304,400.00	994,173,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	763,304,400.00	793,805,500.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		200,368,000.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,352,458,921.38	1,896,628,337.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	533,822,288.51	866,497,477.31
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,108,018,771.03	1,364,581,172.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,108,018,771.03	1,364,581,172.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,019,168,205.44	1,105,338,492.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,908,207.94	504,835,245.07
210101	Үндсэн цалин	209,645,802.08	292,055,177.73
210102	Нэмэгдэл	165,293,657.44	173,368,751.57
210104	Урамшуулал	20,708,300.00	19,815,240.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,260,448.42	19,596,075.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,554,540.61	63,046,443.63
210201	Тэтгэврийн даатгал	35,946,549.07	43,330,260.80
210202	Тэтгэмжийн даатгал	4,074,990.18	4,935,005.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,037,494.90	2,432,227.87
210204	Ажилгүйдлийн даатгал	2,037,494.90	2,424,554.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,458,011.56	9,924,395.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,879,033.93	45,864,359.65
210301	Гэрэл, цахилгаан	5,948,301.93	11,217,700.84
210302	Түлш, халаалт	34,730,732.00	34,646,658.81
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	44,959,615.00	35,944,285.00
210401	Бичиг хэрэг	4,138,950.00	3,458,400.00
210402	Тээвэр, шатахуун	29,062,585.00	20,110,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,254,500.00	2,934,855.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,140,000.00	2,218,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,363,580.00	1,239,500.00
210408	Бараа материал акталсны зардал		5,982,050.00
2105	Нормативт зардал		7,826,807.87

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		7,826,807.87
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,333,700.00	23,580,000.00
210604	Урсгал засвар	16,333,700.00	23,580,000.00
2107	Томилолт, зочны зардал	17,816,000.00	21,820,000.00
210702	Дотоод албан томилолт	17,816,000.00	21,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,401,445.60	39,842,850.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,048,112.00	37,903,546.20
210803	Даатгалын үйлчилгээ	822,440.00	1,022,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	362,993.60	451,788.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	684,000.00	169,000.00
210807	Газрын төлбөр	3,351,900.00	164,516.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	387,315,662.36	362,578,500.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,410,639.20	66,349,287.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,736,850.00	1,752,040.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,850,565.59	259,242,679.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,859,880.00	42,440,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,750,000.00	32,340,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,940,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,169,880.00	10,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	46,990,685.59	216,802,679.87
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,589,102.17	201,114,780.30
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,401,583.42	15,687,899.57
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	244,440,150.35	532,047,165.50
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	160,130,061.32	7,699,320.45
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	131,133,288.98	7,699,320.45
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,025,595.60	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	18,830,585.38	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	9,140,591.36	
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(160,130,061.32)	(7,699,320.45)
V	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	84,310,089.03	524,347,845.05

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	823,507,232.87	1,036,454,387.42
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	4,870,600.00	3,595,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,870,600.00	3,595,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,870,600.00	3,595,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,870,600.00	3,595,400.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	818,636,632.87	1,032,858,987.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,332,232.87	38,685,487.42
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,699,087.00	8,310,684.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,633,145.87	30,374,803.42

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	763,304,400.00	994,173,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,090,392,500.00	1,011,278,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	763,304,400.00	793,805,500.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/		200,368,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	811,903,232.87	1,037,966,387.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,903,232.87	1,037,966,387.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,955,167.28	778,723,707.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422,908,207.94	504,835,245.07
210101	Үндсэн цалин	209,645,802.08	292,055,177.73
210102	Нэмэгдэл	165,293,657.44	173,368,751.57
210104	Урамшуулал	20,708,300.00	19,815,240.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,260,448.42	19,596,075.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,554,540.61	63,046,443.63
210201	Тэтгэврийн даатгал	35,946,549.07	43,330,260.80
210202	Тэтгэмжийн даатгал	4,074,990.18	4,935,005.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,037,494.90	2,432,227.87
210204	Ажилгүйдлийн даатгал	2,037,494.90	2,424,554.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,458,011.56	9,924,395.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,777,618.93	45,864,359.65
210301	Гэрэл, цахилгаан	5,948,301.93	11,217,700.84
210302	Түлш, халаалт	37,282,367.00	34,646,658.81
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	
210304	Байрны түрээс	4,346,950.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	39,720,665.00	26,060,712.00
210401	Бичиг хэрэг	27,372,585.00	2,778,900.00
210402	Тээвэр, шатахуун		16,246,957.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,254,500.00	2,934,855.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,140,000.00	2,218,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,953,580.00	1,881,500.00
2105	Нормативт зардал	1,100,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,100,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,529,200.00	19,997,000.00
210604	Урсгал засвар	19,529,200.00	19,997,000.00
2107	Томилолт, зочны зардал	17,816,000.00	13,810,000.00
210702	Дотоод албан томилолт	17,816,000.00	13,810,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,401,445.60	39,842,850.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,048,112.00	37,903,546.20
210803	Даатгалын үйлчилгээ	822,440.00	1,022,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	362,993.60	451,788.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	684,000.00	169,000.00
210807	Газрын төлбөр	3,351,900.00	164,516.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,147,489.20	65,267,097.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,410,639.20	63,745,057.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,736,850.00	1,522,040.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,948,065.59	259,242,679.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,957,380.00	42,440,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,000,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,750,000.00	32,340,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,940,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,267,380.00	10,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	46,990,685.59	216,802,679.87

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,589,102.17	201,114,780.30
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,401,583.42	15,687,899.57
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,604,000.00	(1,512,000.00)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,000,000.00	
	Дотоод эх үүсвэрээр	11,000,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,000,000.00	
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,000,000.00)	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	604,000.00	(1,512,000.00)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,046,285.79
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,046,285.79	2,534,285.79

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,377,134.26	289,092,476.90	1,591,632,330.87	2,144,101,942.03
2	Тайлант үеийн үр дүн			524,347,845.05	524,347,845.05
3	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,377,134.26	289,092,476.90	1,591,632,330.87	2,144,101,942.03
4	Тайлант үеийн үр дүн			524,347,845.05	524,347,845.05
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,377,134.26	289,092,476.90	2,115,980,175.92	2,668,449,787.08
6	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,377,134.26	289,092,476.90	1,591,632,330.87	2,144,101,942.03

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	996,173,500.00	796,654,119.70	215,207,279.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	996,173,500.00	796,654,119.70	215,207,279.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	953,683,500.00	754,214,119.70	199,469,380.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	556,026,400.00	504,835,245.07	51,191,154.93
210101	Үндсэн цалин	293,272,300.00	292,055,177.73	1,217,122.27
210102	Нэмэгдэл	199,853,500.00	173,368,751.57	26,484,748.43
210104	Урамшуулал	31,386,400.00	19,815,240.00	11,571,160.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,514,200.00	19,596,075.77	11,918,124.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,190,700.00	63,046,443.63	11,144,256.37
210201	Тэтгэврийн даатгал	50,449,600.00	43,330,260.80	7,119,339.20
210202	Тэтгэмжийн даатгал	5,935,300.00	4,935,005.38	1,000,294.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,967,600.00	2,432,227.87	535,372.13
210204	Ажилгүйдлийн даатгал	2,967,600.00	2,424,554.31	543,045.69
210205	Эрүүл мэндийн даатгал	11,870,600.00	9,924,395.27	1,946,204.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,980,700.00	40,980,700.00	
210301	Гэрэл, цахилгаан	5,850,000.00	6,334,041.19	(484,041.19)
210302	Түлш, халаалт	34,730,700.00	34,646,658.81	84,041.19
210303	Цэвэр, бохир ус	400,000.00		400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,338,100.00	22,340,796.00	13,997,304.00

210401	Бичиг хэрэг	3,540,000.00	2,778,900.00	761,100.00
210402	Тээвэр, шатахуун	18,263,100.00	12,587,041.00	5,676,059.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,347,000.00	2,934,855.00	1,412,145.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,888,000.00	2,218,500.00	4,669,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	1,821,500.00	1,478,500.00
2105	Нормативт зардал	1,027,000.00		1,027,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,027,000.00		1,027,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	19,997,000.00	3,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,997,000.00	3,000.00
2107	Томилолт, зочны зардал	17,600,000.00	13,810,000.00	3,790,000.00
210702	Дотоод албан томилолт	17,600,000.00	13,810,000.00	3,790,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,800,600.00	31,311,704.00	8,488,896.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,866,000.00	29,372,400.00	7,493,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,022,600.00	1,022,000.00	600
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,000.00	451,788.00	84,212.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	226,000.00	132,000.00	94,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	605,000.00	169,000.00	436,000.00
210807	Газрын төлбөр	545,000.00	164,516.00	380,484.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,720,000.00	57,892,231.00	109,827,769.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	163,520,000.00	56,370,191.00	107,149,809.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,200,000.00	1,522,040.00	2,677,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,490,000.00	26,752,100.43	15,737,899.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,490,000.00	42,440,000.00	50,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,340,000.00	32,340,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,150,000.00	10,100,000.00	50,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	996,173,500.00	796,654,119.70	199,519,380.30
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	994,173,500.00	796,654,119.70	199,519,380.30
132001	Орон нутгийн төсвөөс	793,805,500.00	694,110,528.70	99,694,971.30
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	200,368,000.00	98,948,191.00	101,419,809.00
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	3,595,400.00	(1,595,400.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00		2,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		3,595,400.00	(3,595,400.00)

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,997,587.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,997,587.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,997,587.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,883,659.65
210301	Гэрэл, цахилгаан	4,883,659.65
2104	Хангамж, бараа материалын зардал	3,719,916.00
210402	Тээвэр, шатахуун	3,659,916.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,531,146.20

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,531,146.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,862,866.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,862,866.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,687,899.57
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,687,899.57
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	15,687,899.57
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,997,587.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,997,587.85
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,310,684.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,686,903.85

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 214,506.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 26,288.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмж, 1,939.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага, буцаан төвлөрүүлэх 3,444.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг хүргүүллээ.

#### Залруулсан алдаа:

Аудитаар нийт 26,288.6 мянган төгрөгийн зөрчил илэрч, аудитын явцад бүрэн залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансыг 24,082.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.
- Байгаль хамгаалах сангаас илүү шилжүүлсэн шимтгэлийн 100.9 мянган төгрөгийн өглөгийг тайлагнаагүй.
- Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн 2,105.0 мянган төгрөгийн авлагыг үр дүнгийн тайланд тусгаагүй.

#### Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 188,217.8 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг арилгах зөвлөмж, давтан гаргахгүй байх албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүллээ.

#### 3.1 Төлбөрийн акт

- Төсвийн хөрөнгөөр ажилтан, албан хаагчдад 2,800.0 мянган төгрөгийн хувцас худалдаж авсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д (*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*) Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*) заасныг зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдаар төлүүлж Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 тоот дансанд 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор төвлөрүүлэх;*

- Орон нутгийн өөрийн өмчийн 644.1 мянган төгрөгийн түрээсийн орлогыг 40%-ийг буюу төвлөрүүлээгүй. Энэ нь Орон нутгийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмын 2.5-д (*Орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлэгч хуулийн этгээд нь орон нутгийн өмчийг түрээсээр эзэмшүүлж олсон орлогын 70 хувийг Байгууллагын өөрийн орлогод төвлөрүүлж, барилга байгууламжийн засвар, үндсэн хөрөнгө худалдан авах зардалд зарцуулж болно. Тус орлогын 30 хувийг Төрийн сангийн Хөрөнгө борлуулсны орлогын дансанд сар тутам төвлөрүүлнэ. Орлогын зарцуулалт, төвлөрүүлэлтийн мэдээг улирал болгоны сүүлийн сарын 25-ны дотор Орон нутгийн өмчийн газарт гаргаж өгнө.*) заасныг зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй 644.1 мянган төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000953 тоот дансанд, хувцас худалдаж авсан 2,800.0 мянган төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 тоот дансанд төвлөрүүлэх;*

### 3.2 Албан шаардлага

- Ажил олгогчоос төлөх нийгмийн 99.0 мянган төгрөгийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 20.2.3-т (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*) заасныг зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн*

- Эхний хагас жилийн тооллогыг дутуу чанаргүй хийсэн (мал амьтан). Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заасныг зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх*

### 3.3 Зөвлөмж

- Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 17 хөрөнгийг хугацаа сунгах саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2-т (*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтээж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*), Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам-ын 5.14-т (*Үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг худалдах, үнийг шинэчлэн тогтоох зорилгоор санал бэлтгэх, тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр хөрөнгийн үнэлгээ хийлгэх*) заасныг зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Элэгдлийн зардлаар анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг хугацаа сунгах саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх*

- Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 182,834.6 мянган төгрөгийн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг бүрэн байршуулаагүй, хуулийн хэрэгжилт 80.5 хувьтай. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн (*Шилэн дансны зарчим (4.1.3-т тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх)*) заасныг зөрчсөн.

*Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулж хэвших. Хариуг 2025.03.25 дотор ирүүлэх.*

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 87.7 хувийг залруулагдаагүй, 12.3 хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт 5,383.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Үүнээс завсрын аудитаар илэрсэн 2,484.1 мянган төгрөгийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан учраас дүгнэлтийн материаллаг байдалд нөлөөлөхгүй. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 2,899.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 10,746.8 мянган төгрөгөөр буюу 4.7 дахин бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансыг илүү тайлагнасан.	1	24,082.6			1	24,082.6	1	24,082.6		
Байгаль хамгаалах сангаас илүү шилжүүлсэн шимтгэлийг өглөгөөр тайлагнаагүй	1	100.9	1	100.9			1	100.9		
Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн авлагыг үр дүнгийн тайланд тусгаагүй	1	2,105.0								
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>26,288.6</b>	<b>1</b>	<b>100.9</b>	<b>1</b>	<b>24,082.6</b>	<b>2</b>	<b>24,183.6</b>		

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдлийн зардлаар анхны өртөгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой 17 нэр хөрөнгийг хугацаа сунгах саналаа холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлээгүй.	1	0					1	0		
Эхний хагас жилийн тооллогыг дутуу чанаргүй хийсэн (мал амьтан)	1	1,840.0			1	1,840.0				
Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн орлогыгн 40%-ийг төвлөрүүлээгүй	1	644.1	1	644.1						
Төсвийн хөрөнгөөр ажилтан, албан хаагчдад хувцас худалдаж авсан	1	2,800.0	1	2,800.0						
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас шилжүүлсэн.	1	99.0			1	99.0				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>5,383.1</b>	<b>2</b>	<b>3,444.1</b>	<b>2</b>	<b>1,939.0</b>	<b>1</b>	<b>0</b>		

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг бүрэн байршуулаагүй, хуулийн хэрэгжилт 80.5 хувьтай.	1	182,834.6			1	182,834.6		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>182,834.6</b>			<b>1</b>	<b>182,834.6</b>		